

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2019 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9 дэх хэсэгт доор дурдсан агуулгатай 6.9.3 дахь заалт нэмсүгэй.

“6.9.3.Гишүүнд эрх бүхий байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол гарсан тохиолдолд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гишүүний бүрэн эрх, халдашгүй байдлаараа ямар нэгэн байдлаар саад учруулахгүй гэдгээ илэрхийлж шалгуулахаар хүсэлт гаргасан бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулж яллах дүгнэлт үйлдсэн тохиолдолд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.9.2 дахь заалт, 6.13 дахь хэсгийг доор дурдснаар өөрчилөн найруулсугай.

“6.9.2.Гишүүнд холбогдуулан эрх бүхий байгууллагаас эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татах тогтоол гарсан, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан тохиолдолд Улсын ерөнхий прокурор түүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг Улсын Их Хуралд оруулсан.

6.13.Гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх эсэх асуудлыг Төрийн байгуулалт, Хууль зүйн байнгын хороодын болон Улсын Их Хурлын гишүүний халдашгүй байдлын дэд хорооны санал, дүгнэлтийг үндэслэн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхийн саналаар, ил санал хураалтаар шийдвэрлэнэ.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2019 оны ... сарын ... -ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг